



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 28 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “онцлог шинжийг агуулсан” гэсний дараа “үндэсний бөхийн барилдаан, сур, шагайн харваа, хурдан морины уралдаан зэрэг үндэсний уламжлалт” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Допингийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол допингийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР